

## АРТЫН МЭРГЭН БАНДИД Б.ДАМБИЙНЯМ (1898-1962)-ЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Л.Чулуунбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

**Өгүүллийн товч утга:** Энэ өгүүлэлд олон түмний дунд хувилгаан гэж шүтэгдсэн эрдэм номтой, мэргэн нэгэн өвгөний хэлмэгдэн яллагдсан тухай товч өгүүлнэ. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн эмгэнэлт амьдралын талаар гүнзгийрүүлэн судлах нь иргэний нэр төрийг сэргээхэд төдийгүй, эх орны түүхийн үнэн зөвийг тодотгон эрхэмлэхэд чухал ач холбогдолтой билээ.

**Түлхүүр үг:** Хувилгаан, уяач, хэлмэгдэл, эмгэнэл, ялтан, цагаатгал.

### Оршил

Монголын нийгэмд эмгэнэл, гашуудал, айдас төрүүлсэн улс төрийн тухайн үеийн эрдэм номтой, авъяас чадвартай хүмүүсийг егүүтгэн өөрт нь болон хойч үеийнхэнд гүн хар толбо, нөхөж баршгүй шарх сорви үлдээсэн билээ. Тийм хэлмэгдүүлэлтийн золиос болсон нэгэн эрдэмтэй ламын тухай өгүүлэх нь танин мэдэхүйн төдийгүй, улс төр, практикийн ихээхэн учир холбогдолтой. Энэ хүний талаар нутгийн хүмүүсийн дунд ам дамжсан хууч яриа их боловч намтар, дурьдатгал судлалын үүднээс тусгайлан судалж, ном товхимол, өгүүлэл бичсэн зүйл байхгүй ажээ. Иймээс судалгааны бүтээл судлах, аман асуулгын аргаар мэргэн бандид Б.Дамбийнямын тухай товчхон ойлголтыг энэ өгүүлэлд өгөх болно. Энэ нь цаашид архивын баримт, Цагаатгалын комиссоос гаргасан ном, хэрэглэгдэхүүнийг үндэслэн судалгааг гүнзгийрүүлж, товхиц бичих боломжийг олгосон билээ.

Нутаг орныхоо ард олны хууч ярианд домог болон хэлцэгдэж, их хүндэтгэлийг эчнээ хүлээсэн нэгэн өвгөний зураг Хэнтий аймгийн Галшар сумын Их Арт уулын орчмын айл болгонд байгаа нь анхаарал татаж, энэ өгүүллийг бичихэд өөрийн эрхгүй хөтөлсөн юм. Хуучин социализмын үед нам, засгийн удирдагчдын зургийг айл өрх, албан байгууллагад хүндэтгэлтэй залж, хэлсэн, ярьсан болгоныг хууль мэт дагаж, бишрэн шүтэж байсан юм. Тэгвэл энэ өвгөн нам, төрийн алба хашиж явсангүй. Харин ч тус оронд болсон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, 10 гаруй жил "аавын"-д заларч байжээ. Ийм атал өдгөө олны хайр хүндэтгэлийг хүлээх ямар гавъяа зүтгэлтэй, ямар буян заяатай нэгэн бэ? гэдэг асуудал олон жилийн туршид хүмүүст тодорхойгүй, оньсого мэт учир битүүлэг ажгуу.

Энд өгүүлэн буй Арт уул бол өнөөгийн Галшар сумын нутгийн хойд хэсэгт орших бөгөөд XVIII зууны үеийн архивын баримтанд: Сэцэн хан Махширын хошууны өмнө этгээд Арт уулын зэрэг газруудад дэд, да хэбэй, бэйс Гончигжавын хошуу (1;3) зах нийлдэг гэжээ. Энэ бол Сэцэн ханы гол хошууны хамгийн өмнөд цэг, Бишрэлт засгийн хошууны умард хил нь Арт уул гэдгийг тодорхой харуулж байна. Арт уул нь далайн түвшингээс 1418 метр өндөр өргөгдсөн, Монголын их боржингийн бүсэд багтдаг, эртнээс тахиж байсан ажээ. Энэ орчмын газар нутаг нь өвс ургамлын гарц сайтай, шөрмөсөн чулуутай, үзэсгэлэнтэй өвөрмөц тогтоцтой юм. Уг нутаг орноос удамт хурдан хүлгүүд нь улс даяар алдаршсан, ухаант өвөг дээдэс нь Халх даяар цуутай бөлгөө. Тийм алдар цуутнуудын дотроос олонд "өвгөн ноён" гэж хүндлэгдсэн хардэл жанжин бэйс Мижүүрдоржийн Пүрэвжав (1844-1937) үе залгамжлан хошуу захирч, 1885 онд "Харъяат хошуундаа дагаж явуулахаар тогтоон тушаасан ухуулах бичиг"-ийг гаргаж, бэлчээр нутгийн талаар их анхаарч байжээ. Мөн тэрээр хошууныхаа хүлэгч шинжээчдийн хамт "Нууцаас нууц, далдын далд шулуун журамт" хэмээх хурдан морь таних, сойх, шинжийн судрыг бичиж, чандлан нууцалж байжээ. Иймээс өвгөн ноёны үед алдар суугаа мандуулсан хилэн хар, номин цэнхэр, зул

хонгор, Арслан хул, өлгөр хүрэн, Зандан хүрэн, Элбэг хээр зэрэг домогт хүлгүүд (2;192) тод магнай, торгон жолоо өргүүлж иржээ. М.Пүрэвжав, Б.Дамбийням хоёр тавь гаруй насны ах дүү, нэг нутаг усны хүмүүс бөгөөд бүр 1930-аад оны эхээр хамт баривчлагдсан юм. Өвгөн ноён М.Пүрэвжавыг нас өндөр, бие чилээрхүү тул сүйх тэргээр авч яваад урьдын үе залгамжилсан хошуу захирагчийн хувьд "ардын дайсан", "хувьсгалын эсэргүү" нэрээр шоронд хорьж байгаад сулласан байна.

Харин Б.Дамбийнямын хувь тавилан өөрөөр эргэсэн ажээ. Б.Дамбийням гэж хэн байсан бэ? Зарим ном зохиолд түүний нэрийг өөр, өөрөөр бичсэн байдаг. Жишээ татвал, Б.Жамъяндамбийням (3;36) Наваанлуvsсандамбийням (4;64) гэх мэт нэрлэгдсэн нь зарим хүмүүсийн үзэж байгаачлан, лам нэр төдий биш, өөрөө нэрээ нууцлах, бас нэг орон нутагт тогтвортой оршин суудаггүй, аймаг хошуу, айл хотлоор хэсүүчлэн явж байсан зэрэгтэй холбоотой. Би энэ удаад нутгийн хүмүүсийн нэрлэж заншсаныг эш үндэс болголоо.

Балбарын Дамбийням 1898 оны хулгана жилийн өвлийн тэргүүн сарын шинийн 3-нд Халхын Сэцэн хан аймгийн Бишрэлт бэйсийн хошуу (одоогийн Хэнтий аймгийн Галшар сум)-ын нутагт Цэнд бүсгүй хоёр дахь удаа няраалжээ. Эцэг Балбар нь ядуу амьдралтай ард хүн байжээ. Харин эх Цэнд сайн зураач хүний охин байсан гэдэг. Цэндийн эцэг Жигжид нь зургаан улсад тэргүүн зураачид тооцогдож бурхны хөрөг зурж, бас алт, мөнгөөр эдлэл хийдэг их уран хүн байжээ. Жигжидийн зурсан зураг нутгийн өвгөн Жорвоогийнд хадгалагдаж байдаг ажээ. Жигжид нэг удаа арвай будаагаар арслан сийлээд Богдод явуулсан гэдэг яриа байдаг гэнэ. Жигжид эзэн ноёндоо хар больё гэж айлтгаад, эхнэр авч 5 охин, 1 хүүтэй болсны тав дахь нь Цэнд байжээ. Дамбийнямыг эхээс мэндлэх үед нутгийн өвгөн Цагааных айл байж, Цагааны эх Лувсан хожмын их хувилгааныг эх барьж авчээ. Б.Дамбийнямыг эхээс мэндлэх агшинд гэр дүүрэн шар гэрэл цацарч, манцуйлснаас хойш уг гэрэл байхгүй болсон гэлцдэг байна. Тэр шөнө адуу манаж байсан нутгийн өвгөн, урьд шөнө Балбарынх шатчих шиг боллоо гээд давхиад иртэл, эхнэр Цэнд нь нярайлж хүүтэй болсон байжээ. Б.Дамбийнямыг 5 нас хүрэхэд Артын уулан дахь ламын хийдэд суулгажээ. Тухайн үед хувилгаан дүрийн хойтыг тодруулахаар хулгана жилтэй 5 хүүхдийг Богдод сунтаг шүүлгэхээр явуулахад Дамбийням тодорсон гэдэг байна. Сунтаг шүүлгэж байгаа 5 хүүд Богд бууны гол төмөр өгч сориход, Дамбийням түүнийг хурданг эргүүлж чадсан юм гэнэлээ хэмээн нутгийн өвгөчүүл хуучилдаг. Тэр үеэс хойш Б.Дамбийнямыг нутгийнхан хувилгаан гэж шүтдэг болжээ. Тэрээр 5-18 нас хүртэл Артын уулын ламын хийдэд сууж байгаад, 20 гаруй насандаа өөрийн саналаар ан гөрөө хийж, морь уядаг байжээ. Энэ нь залуу халуун насны омголон хүсэл, нутгийн цуутай уяачдын шууд нөлөөтэй холбоотой байсан буй за. 1920-иод оны үед Б.Дамбийням агь гүн Пунцагнамжилын дүү ноён Доржцэрэнгийн хоёр дахь охин Уртнасантай дэр нэгтгэн амьдарч байгаад удалгүй салж, одоогийн Өмнөдэлгэр сумын Дунгартай ханилж, Хутагтын хүрээнд байжээ. Улмаар түүнийг 1930-иад оны үед нутагтаа ирэхэд, 1931 оны үеэс цаг төр үймэж, лам ноёд, хутаг хувилгаадыг барьж эхэлжээ.

Анх Б.Дамбийнямыг баривчлуулахаар Дотоодыг хамгаалах газраас Гомбожав гэдэг хүнийг явуулжээ. Дамбийнямыг гэрийнхээ зүүн орон дээр сууж байхад, Гомбожав гэрт орж хүмүүсээс асууж сураглаад, өөрийг нь хараагүй явсан гэнэлээ хэмээн хуучуул ярьдаг байжээ. Дараагийн удаад Б.Дамбийнямыг өвгөн ноён М.Пүрэвжав, туслагч Алтангэрэл нарын хамт барьж, Галшараас аймгийн төв хүргэхээр "шийр" хэмээх Чойжамц авч явжээ. Хэрлэнгийн гүүрний урд ирэх үед Дамбийням Чойжамцыг мориноос нь түлхэж унагаагаад, Алтангэрэлийн хамт нутгийн зүг зугатжээ. Тэр хоёр Арт ууланд ирж, Алтангэрэлийгээ Залаа хадны өвөрт буулган, суусан газрыг нь Дамбийням тойрог маягаар зурж, "би морио солиод ирье, чи хөдлөлгүй энэ газраа сууж

байгаарай” гээд ойролцоо байсан нутгийн өвгөн Бүл Жанжаагийн дэргэд очжээ. Түүнийг морио юулж ирэхэд, Алтангэрэлийг нь бариад явчихсан мөр байжээ. Алтангэрэл зурсан тойргоос өөрөө гарсан учраас баригдаж, ганцаар үлдсэн Дамбийням хил давж амьд гарах, эсэхээ үзэхээр сэтгэл шулуудаж, Өвөр Монгол руу зугатжээ.

Энэ үе бол 1932 оны намар өвлийн зааг байсан бөгөөд хил орчмын зарим айл, хэсэг бүлгээрээ хүмүүс гадагш дүрвэж хөл хөдөлгөөн ихтэй, харуул хяналт ч чангарсан байжээ. Гэвч Б.Дамбийням Дорноговь аймгийн нутаг Аргалын уулын баруун талаар явж монгол улсын хилийг давж, өвөр Монголын Сөнөд хошууны Зараагийн сүмд очжээ. Тэр нутгийн зарим хүмүүс ар халхын Артын мэргэн хувилгаан ирлээ гэж хүндэтгэн угтсан байна. Тэнд Дамбийням 2 жил болоод, нутагтаа сэмхэн ирж, Талын усанд байсан гэрээсээ Дунгарыгаа мориор авч нууцаар буцсан ажээ. Дараа нь тэд Өвөр Монголын нэг айлаас охин өргөж авч 15 нас хүртэл уг айлынхтай хамт байтал Дунгар нь өөд болжээ. Б.Дамбийням эхнэртээ зориулж бурхан бүтээгээд, 1945 оны IX сард эх нутагтаа буцаж иржээ. Б.Дамбийням хилийн чанадад 13 жил байхдаа, зөвхөн Өвөр Монголд байсан уу, эсвэл Түвд, Энэтхэг хүртэл явсан уу гэдэг нь тодорхойгүй. Зарим бүтээлд, түүнийг 1945 онд баригдаж ирсэн (5;36) гэж бичжээ. Мөн Б.Дамбийнямыг бандид лам гэж нэрлэдэг. Энэ цолыг хэзээ, хэнээс түүнд олгосон тухай тодорхой мэдээ алга.

Бандид гэдэг нь Энэтхэг оронд очиж хүртсэн эрдмийн цол юм. Энэтхэгт бүх эрдэм ухааныг таван зүйлд хуваадаг, эдгээрт мэргэжсэн хүнд Бандид цолыг олгодог байжээ. (6;5) гэсэн тайлбар бий.

Б.Дамбийнямыг эх орноос урвасан гэж үзэж, дотоод яамныхныг байцаалт авахад, түүний мэргэн, "эгэл биш" нь нотлогдсон гэж хүмүүс ярилцдаг. Тухайлан ганц нэг жишээ татахад, "чи яаж улсын хил давсан бэ? гэхэд, "байцаагчийн ширээн дээгүүр нүдгүй цасан шуурга шууруулсан", бас "дарга та намайг байцаах яах бэ, цаана чинь таны эхнэр төрөх гээд өвдөж байна" гэсэн нь үнэн байсан гэх зэрэг хүмүүсийн ам дамжсан домог мэт яриа олон юм. Энэ бүхэн нь Б.Дамбийнямыг үнэхээр мэргэн, их эрдэмтэй, ховор авъяас чадвартай гэдгийг нотлох нэлээд хэтрүүлэгтэй нь ойлгомжтой боловч олны үг ортой болохыг бас харуулж байна гэж үзүүштэй.

Мэргэн бандид лам Б.Дамбийнямд эх орноосоо урвасан хэмээн 15 жилийн хорих ял оноож, Амгаланд агт мал, аж ахуйн ажил хийлгэж байжээ. Бандид ламтай хамт ял эдэлж байсан Жүрмэдийн Лодоншарав дурсан ярихдаа: "Б.Дамбийням үг дуу цөөнтэй, их дөлгөөн хүн байсан. Нэг өдөр намайг чи гэр, орон нутгаа их санаж байна даа. Би чамд нэг морь олж өгье, чи яг 7 хоног яваад ирнэ шүү, хэтрүүлж болохгүй гэсэн. Ингээд нэг оройхон эмээл хазаартай сайхан морь авчирч өглөө. Би тэр морийг унаад жигдхэн ергөөд байтал, шөнө дундаас өмнө Салбарын уулын (Мөрөн сум) дэргэд ирсэн. Би өөртөө ч итгээгүй. Хожим бодоход, бандид лам дэрнийхээ дор байнга хадгалдаг эмээл хазаартай морины зургаараа л надад тусалсан болов уу. Өөрөөс нь асуухад ер хэлж өгдөггүй байсан" гэжээ. Б.Дамбийнямыг таньж мэдэх болон хамт ял эдэлж байсан хүмүүсийн ярианд, онцгой анхаарал татаж буй нэг зүйл бол бандид лам элдэв зүйлээр зориуд мэргэ төлөг тавьдаггүй, шууд л хэлдэг, ер нь зарим хүнд асуусан юмыг нь хэлж өгөх дургүй, бас уулзах ч хүсэлгүй байдаг гэжээ. Энэ нь түүний хувийн онцлог мөний зэрэгцээ ном эрдэмд гүн нэвтэрсэн, бас өвөрмөц чадавхитай холбоотой байж болох бөгөөд зургаа дахь мэдрэхүй нь үлэмж хөгжсөн байсныг үгүйсгэх үндэсгүй.

Б.Дамбийням 11 жил биеэр ял эдлээд, төр засгийн өршөөлөөр 1956 оны IX сард суллагдаж, орон нутагтаа ирж амьдралынхаа сүүлийн жилүүдийг дүү Гэндэнжамц, Норовоо, ах Цагаан өвгөн нартай хамт өнгөрөөжээ. Тэрээр 1962 онд 64 настайдаа таалал төгсжээ.

Артын мэргэн бандид Б.Дамбийнямын амьдрал, хувь тавилангийн тухайд зурвасхан өгүүлэхэд ийм буюу. Түүний амьдрал оноо алдаа хосолсон, оньсого мэт үл тайлагдам нууц үлэмж, зориуд нягтлан судалбал зохих зүйл тун их юм.

Бандид лам "Би олбогоо цоолооч гэсэн. Миний дараах үе олонцогоо цоолох хүн болно", "Буруу цөвүүн цаг нүүрлэсэн энэ үед Буянтад шилжих нь дээр юм. Буяны цаг ирэхээр хошуу нутаг сэргэх тавилантай" гэж айлдсан гэдэг. Нутгийнхаа шүтээн энэ хувилгаан Галшарын дархан Лувсандагвын гэдэг айлаар байдаг байсан бөгөөд хувилгаанд зориулсан суврагыг Лувсандагвын хүү Мягмаржав тэргүүтэй хүмүүс Их Артын энгэрт өөрийнх нь хийдийн суурин дээр босгосон байна. (7:225)

Их Артын энгэрт Б.Дамбийнямын шавилан сууж байсан ламын хийдийг Бандид ламын хийд гэж нэрлэдэг байжээ. Энэ нь Бишрэлт бэйсийн хошууны 9 хийдийн нэг юм. 1990-ээд оноос хойш Бишрэлтийн хошууны гол хийд болох Ганданшадавадаржаалинг сэргээж, Галшар сумын хуучин төв Хужиртад байнгын хуралтай болгоход Ишдоо зэрэг өвгөн лам нар их идэвх зүтгэлтэй оролцсон байна. Энэ үйл явдлыг нутгийн олон түмэн, Бандид ламын хэлсэн нь биелэл боллоо гэж ярилцаж байжээ.

Нутгийн айлуудад Бандид ламын хэрэглэж байсан Ловон Бадамжунай, Жадаахуушин бурхан, мөн дээл нь хадаглагдаж байдаг бөгөөд нутгийн залуус эр цэргийн албанд мордохдоо бандид ламын дээлийн хэсгээс урж биедээ авч явдаг ажээ.

Энэ бүхнээс эргэцүүлэн үзвэл, Балбарын Дамбийням нь багаасаа сэргэлэн цовоо, ухаан уужим, эрдэм номд хичээнгүй нэгэн байсны хувьд их эрдэмт лам болжээ. Түүний үзэл, эрдэм номын хэрэгт нэрт гүн ухаантан, Тунгалаг цорж лам Балдан хэмээх Занын Агваанбалдан, Хардэл жанжин бэйс, өвгөн ноён Мижүүрдоржийн Пүрэвдорж зэрэг нутгийн том эрдэмтдийн нөлөө үлэмж байсан нь тодорхой.

1930-аад оны эхээр шашин сүм хийд, лам хувраг, хутагт хувилгаад нарын эсрэг хомрогolon баривчлахад Б.Дамбийням оргон зайлж хилийн чанадад 10 гаруй жил болжээ. Тэрээр Өвөр Монголын сөнөд хошууны Зараагийн сүм, Утай гүмбэм, улмаар Түвдийн Лхас, Энэтхэг хүртэл явж, тэндээс Бандид цол хүртсэн бололтой. Харин 1945 онд дайн дуусах үед Өвөр Монголд байсан учраас баригдсан ажээ. Тэр үед эхнэр нь өвчтэй, эсвэл дөнгөж таалал төгссөн байж болох тул Энэтхэгээр дамжин өөр оронд зугатан гарах боломжгүй байсан болов уу. Нөгөө талаар, эх нутагтаа үлдсэн элгэн садан, олон шавь хуврагууддаа ч сэтгэл хорогдоод алсад одоогүй байж болно.

Бандид лам Б.Дамбийнямын амьдрал, эрдэм чадлын тухайд орон нутагт ахмад настнуудаас асууж сурвалжлах, архивын баримт сэлтийг шүүн нягтлах, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн талаарх судалгааны бүтээлүүдийг үзэх замаар бэсрэг товхимол бэлтгэх бодолтой байна. Энэ нөхцөлд бидний эргэцүүллийн нарийн учир холбогдол тодорхой болж, олон ээдрээтэй асуудлын учгийг тайлах боломж бүрдэнэ гэдэгт бат итгэж байна.

Хэнтий аймгаас Ламаадан буюу мэргэн жаал Цэрэнпунцаг, мэргэн шовгор хэмээх Ишжамц, хувилгаан Минжүүр, Чогсом зэрэг өвөрмөц арга чадвартай хүмүүс тэрж гарсан юм. Урьд өмнө эдгээр хүмүүсийг ад шоо үзэж, олон түмнийг мунхруулан төөрөгдүүлэгчид гэж үл тоомсорлож байв. Гэвч тэдний тухай жирийн иргэд хүндэтгэлтэй хандаж, арга чадвар, ховор авъяас билгийг нь ам дамжин шагшин магтсаар өдгөө хүрсэн билээ. Цаашид ийм хүмүүсийн талаар ул суурьтай судалгаа явуулж, ховор заяасан авъяас чадварыг нь үнэн зөв үнэлж дүгнэх явдал чухал байна. Түүхийн ээдрээ бартаатай нугачаанд хичнээн ч гоц авъяастнууд онож алдаж, адлагдаж явсныг зөвхөн бандид лам Б.Дамбийнямаар жишээлэн өгүүлэхэд, хүний хорвоод сайн, муу, авъяастай, аргатай, буянтан, нүгэлтэн зэрэгцэн оршсоор ирсэн болохоор түүхийн үнэн байх зарчмаар

амьдрал, хувь тавилангийн нь тухайд тэр түүхт хүмүүсийг эрэн сурвалжлах, нэхэн эргэцүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Тэднээс суралцах, санаа авах, сургамж болгох зүйл их байна.

*Хорвоогийн хүн зон амгалан байх болтугай.*

**Abstract:**

This article aims to provide a brief outline of thoughts about the Wise Pandita B.Dambiynima of Arta, persecuted and executed during the mass terror of the 1930s for being a well-educated proest and a sightly skillful person. The article proposes a further research to be conducted on the biography of this remarkable individual.

**Эшлэл татсан архивын баримт,  
зарим ном зохиол**

1. Халхын Сэцэн хан аймгийн Бишрэлт бэйсийн хошууны зураг. // УТТА.фм 81, д.1, х/н 3
2. Ж.Саруулбуян. Хан Хэнтийн товчоон. УБ., 2003 он
3. А.Баярмагнай. Галшарын товч түүх. УБ., 2000 он
4. Х.Нямбуу. Халхын Махасамади Сэцэн ханы аймаг. // ЗГМ, № 64, 1994 он
5. А.Баярмагнай. Галшарын товч түүх. УБ., 2000 он
6. Эрдэнийн сан Субашид. УБ., 1990 он
7. Н.Санжаадорж. Галшар гэж бичихэд ган амгай дугтарна (Хэнтий аймгийн Галшар сумын түүхээс). // Өдрийн сонин, №225, 226 (1098, 1099) 2002 он
8. Сэцэн ханы ургийн бичиг. // УТТА. Фм. 233, т.1, х/н 130